



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

**ТУХАЙН ШАТНЫ СОНГУУЛИЙН  
ХОРООНД**

2024.07.04 № 266.

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Дархан-Уул аймгийн Орхон сумын "Монгол ардын нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 – 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 – 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны

009020366

төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.


### Дүгнэлт

Дархан-Уул аймгийн Орхон сумын “Монгол ардын нам”-ын орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Орхон сумын “Монгол ардын нам”-ын мөрийн хөтөлбөр(*22*.....хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Орхон сумын “Монгол ардын нам”-д

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



/Ш.МӨНХБАЯР/

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ОРХОН СУМЫН  
МОНГОЛ АРДЫН НАМ

АЙМАГ, СУМЫН ИТХ-ЫН 2024 ОНЫ 9 ДЭХ УДААГИЙН  
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ДЭВШҮҮЛСЭН

ТОГТВОРТОЙ БОДЛОГО ТОЙТВОРТОЙ ХӨГЖИЛ  
ШИНЭ СЭРГЭЛТ – ШИНЭ ХОТ  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР  
(2024-2028)

2024 он



## ХӨТӨЛБӨРИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛСАН ТАЛААРХ

### ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Нэг. Хөтөлбөрийг дараах эрх зүйн болон бодлогын баримт

бичгүүдэд нийцүүлэн боловсрууллаа. Үүнд:

1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль
3. Улс төрийн намын тухай хууль
4. “Алсын хараа -2050” хөгжлийн хөтөлбөр
5. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл
6. “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөн
7. “Хүнсний хангамж, аюулгүй байдал” хөтөлбөр
8. “Шинэ сэргэлтийн бодлого”
9. “Шинэ хоршоо” хөдөлгөөн
10. Монгол Ардын Намын 2024 оны УИХ-ын сонгуульд оролцох “ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО – БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН РЕФОРМ” мөрийн хөтөлбөр
11. Дархан хотыг 2020-2035 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн Ерөнхий төлөвлөгөө
12. Дархан-Уул аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн хөгжлийн үндсэн чиглэл
13. Орхон сумын “Хөгжлийн стратеги төлөвлөгөө “2016-2025 он”

Сумын төсөвт 6 байгууллага, намын гишүүдээс ирсэн 57 санал, сумын иргэдээс ирсэн 113 саналыг нэгтгэн судалж төсөлд тусгалаа.


Хоёр. Сумын Монгол Ардын Намын Хорооноос 2020 оны орон нутгийн ээлжит сонгуульд оролцсон 6 бүлэг, 13 дэд бүлэг, 69 зорилт арга хэмжээ бүхий “Тогтвортой бодлого - Тогтвортой хөгжил” мөрийн хөтөлбөр дээр үндэслэн сумын Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулсан байна.

Уг хөтөлбөрт Намын мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээнүүд шууд болон шууд бусаар 6 зорилт 45 арга хэмжээг төлөвлөн орсон бөгөөд 2023 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилт 99 хувийн биелэлттэй байна.

Гурав. Орхон сумын Монгол Ардын Намын Хорооноос 2024 оны орон нутгийн ээлжит сонгуульд оролцохоор 6 бүлэг, 17 дэд бүлэг, 97 зорилт арга хэмжээ бүхий “Тогтвортой бодлого - Тогтвортой хөгжил, Шинэ сэргэлт – Шинэ хот” мөрийн хөтөлбөрийн төслийг боловсрууллаа.

3.1 Хөтөлбөрийн төсөлд тусгасан хөгжлийн бодлогын баримт бичгүүд:

- “Тогтвортой ажилтан” хөтөлбөр,
- “Багшийн хөгжил” хөтөлбөр,
- “Орон нутгийн тэтгэлэг” хөтөлбөр,
- “Халамжаас хөдөлмөрт” хөтөлбөр,
- “Цалинтай эх, эцэг” хөтөлбөр
- “Хоггүй хот” төсөл,
- “Түрээсийн сууц” төсөл,
- “Кинонд ээлтэй хот” төсөл,
- “Атар – IY” аян,
- “Шинэ хоршоо” хөдөлгөөн,
- “Өрх бүр үйлдвэрлэгч” хөтөлбөр,
- “Ажил олгогч өрх, иргэн” хөтөлбөр,
- “Шинэ хөдөө” төсөл,
- “Төрийн албан хаагчийн сургалт” хөтөлбөр,
- “Нийгмийн баталгаа” хөтөлбөр,
- “Төрийн ажилтны орон сууц” хөтөлбөр,



Агуулга

**НЭГ.ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГО**

- 1.1. Эрүүл мэнд
- 1.2. Боловсрол
- 1.3. Соёл урлаг, спорт
- 1.4. Хөдөлмөр эрхлэлт

**ХОЁР. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ**

- 2.1. Эдийн засаг
- 2.2. Дэд бүтэц, бүтээн байгуулалт

**ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ**

- 3.1. Байгаль хамгаалал
- 3.2. Ногоон байгууламжийн чиглэлээр

**ДӨРӨВ. УХААЛАГ ЗАСАГЛАЛ, УХААЛАГ БҮТЭЦ, ЧАДВАРЛАГ АЛБАН ХААГЧ**

- 4.1. Иргэнд ээлтэй төрийн үйлчилгээ
- 4.2. Ухаалаг төрийн үйлчилгээ
- 4.3. Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба
- 4.4. Эрх зүй, батлан хамгаалах, гамшгаас хамгаалах бодлого



**ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙ**

- 5.1. Газар тариалан
- 5.2. Мал аж ахуй
- 5.3. Туслах аж ахуй

**ЗУРГАА. ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ**

- 6.1. Хүнсний ногооны боловсруулалт ба түгээлтийн үйлчилгээ
- 6.2. Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх



## Нэг. Хүний хөгжил, Нийгмийн бодлого

Хүний хөгжлийн үндсэн үзүүлэлтүүд болох эрүүл мэнд, боловсрол, нийгмийн бусад суурь үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, иргэн бүрт тэгш боломж бий болгож, хүний амьдрах таатай орчин нөхцлийг бүрдүүлэхэд онцгой анхаарч, өрх, иргэдээ тогтмол ажилтай, орлоготой байхад бүх талаар дэмжлэг үзүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулна.

### 1.1. Эрүүл мэнд

1.1.1. Иргэдийн эрүүл зөв хооллолт, стрессээ удирдах, хөдөлгөөний хэмсдолоос сэргийлэх, бие бялдраа хөгжүүлэх дасгал хөпөлгөөн, иог бүжиг хийх зэрэг цогц үйлчилгээ бүхий **“ЭРҮҮЛ ЗӨВ АМЬДРАЛ”** хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.1.2. Хүүхдийн “Эрүүл шүд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.1.3. Эрүүл зөв дадал эзэмшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах багш, мэргэжилтэн, сургагч багш нарыг бэлтгэж мэдлэг чадвар болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажиллах, сургах арга зүйг тогтмол сайжруулах боломжийг бүрдүүлнэ.

1.1.4. Эмнэлгийн тусламж, үйлчилгээг ил тод, хариуцлагатай байлгаж, шуурхай хүргэх зорилгоор өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт мэдээлэх, эрүүл мэндийн төвийн цахим шилжилтийг эрчимжүүлж, “Шилэн эмнэлэг”, “Цахим эмнэлэг” төслүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.1.5. Эрүүл мэндийн үзлэг, эрт илрүүлгийг оновчтой, эрсдэлд суурилсан байдлаар тасралтгүй үргэлжлүүлнэ.

1.1.6. Уламжлалт анагаах ухааныг хослуулан уламжлалын эмчилгээний өрөөг шинээр байгуулж эмч мэргэжилтэнгийг сургаж тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

1.1.7. Алслагдсан багийн иргэдэд эрүүл мэндийн салбарын тусламж үйлчилгээг чанартай жигд хүргэх, техник шинэчлэлийг хийж туулах чадвартай тусламж үйлчилгээний түргэний машины шинэчлэлийг хийнэ.

1.1.8. Эрүүл мэндийн төвийн гадна пассад тохижилтыг шинэчлэнэ.

### 1.2. Боловсрол

1.2.1. “Боловсрол -2032” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.2.2. “Багшийн хөгжил” хөтөлбөрийг шинээр, “Чадварлаг багш” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.2.3. Ерөнхий боловсролын масс сургалтын чанарын үнэлгээний гүйцэтгэлийн хувийг нэмэгдүүлнэ.

1.2.4. Боловсролын чанарыг сайжруулж чанартай боловсрол олгох суралцагч нэг бүрийг амжилттай суралцахад чиглүүлнэ.

1.2.5. “Чадварлаг багш, оюунлаг хүүхэд”, хөтөлбөрийг хэрэгжүүлж суралцах орчинг шинэ дэвшилд хүргэж шинэ сургууль барина.

1.2.6. Цэцэрлэг, сургуулийн материаллаг баазыг нэмэгдүүлж, гадна, дотор орчныг камержуулж, хүүхэд эрүүл, аюулгүй орчинд сурч, хүмүүжих нөхцөлийг бүрдүүлнэ.

1.2.7. Сургуулиудын номын санг шинэчилж, хими физик, биологийн хичээлийн лаборатори танхим, орон нутгийн онцлогийг харуулсан туршилтын талбай шинээр байгуулна.

1.2.8. Боловсролын салбарын багш, ажилчдын ажиллах нөхцөлийг сайжруулж, нийгмийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.

1.2.9. Хичээлээс гадуурх секц, дугуйлангуудыг бодлогоор дэмжиж, хүүхдийг өөрийн авьяаст нь тулгуурлан хөгжүүлж, амьдралын зөв дадалд сургах бодлого баримтална.

1.2.10. СӨБ-ын багш ажилтаны ур чадварыг дээшлүүлэх, тогтмол сургалтанд хамруулах, одоогийн 9-р цэцэрлэгийн үндсэн байрыг их засварыг хийж хүүхэд багачуудын суралцах таатай орчинг бүрдүүлнэ.

1.2.11. 9-р цэцэрлэгийн болон гэр цэцэрлэгийн гадна пассад, тохижилтыг шинэчлэнэ.

1.2.12. Хүүхдийн автобусны парк шинэчлэлийг хийж шинэ автобустай болно.

### 1.3. Соёл урлаг, спорт

1.3.1. “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг үргэлжлүүлнэ.

1.3.2. “Кинонд ээлтэй сум” арга хэмжээг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлж өөрийн сум орон нутгийн дэлгэцэнд мөнхөлж сурталчлах ажлыг зохион байгуулна.

1.3.3. Хүүхдийн тоглоомын талбайг тохижуулж, “3х3” сагсан бөмбөгийн стандарт талбайг Баян Өлзийт болон Энхтал багуудын хорооллуудад барьж байгуулна.

1.3.4. Өвлийн спортын төрлүүдийг хөгжүүлж, “Хоккейн талбай” байгуулна.

1.3.5. Соёлын үйл ажиллагааг идэвхижүүлж материаллаг баазыг нэмэгдүүлэн орчин үеийн чанар стандартын шаардлагад нийцсэн хөгжим техник хэрэгсэлийн шинэчлэлийг хийнэ.

1.3.6. Сумын түүхэн үйл, орон нутгийн судлах танхимыг орчин үеийн стандартын шаардлагад нийцүүлэн тохижуулна.

1.3.7. Сумын иргэд, хүүхэд залуусыг олон төрлийн секц дугуйлангаар суралцаж хичээллэх нөхцөл боломжийг бүрдүүлж мэргэжлийн боловсон хүчнээр хангаж үндэсний спортыг хөгжүүлнэ.

1.3.8. Соёлын төвийг орчин үеийн тоноглол бүхий тайз гэрэлтүүлэгийг хийж нэг давхарын их засварыг хийж гүйцэтгэнэ.



1.3.9. Сумын түүх соёлын биет болон биет бус өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж түүнийг сурталчлах ажлыг хүүхэд багачууд сумын иргэдийн дунд зохион байгуулах ажлыг жил бүр хийж хэвшүүлнэ.

1.3.10. Хүүхэд багачуудад ардын бие биелгээ язгуур урлагийг хөгжүүлнэ.

1.3.11. Соёлын төвийн гадна тохижилт пассада шинэчлэлийг хийж дуусгана.

#### **1.4. Хөдөлмөр эрхлэлт**

1.4.1. “Халамжаас хөдөлмөрт” хөтөлбөрийг хэрэгжүүлж, зорилтод өрхийн судалгааг шинэчлэн халамжаас хөдөлмөрт шилжих ажилтай орлоготой өрх иргэнийг төлөвшүүлнэ.

1.4.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөр, жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн уялдааг хангаж зорилтод бүлэгт дэмжлэгийг оновчтой хуваарилж ажлын байрыг нэмэгдүүлнэ.

1.4.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажилтай орлоготой болгох талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

1.4.4. Нийгмийн халамжийн тусламж дэмжлэг үйлчилгээнд зорилтод эмзэг бүлгийг хамруулж амьжиргааг дээшлүүлэхэд чиглүүлж орон нутгийн онцлогт нийцсэн олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээг нэвтрүүлнэ.

#### **2. Төсөр. Эдийн засаг, хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлт**

Төсвийн сахилга батыг чанд сахиж, хөрөнгө оруулалт, банк, санхүү, даатгалын оновчтой зөв бодлого хэрэгжүүлж, бизнесийн таатай орчныг бий болгоно.

##### **2.1 Төсөв, санхүү, эдийн засаг**

2.1.1. Төсвийг үндэслэлтэй төлөвлөх зорилгоор иргэд, төрийн бус байгууллагын оролцоог хангуулна.

2.1.2. Төсвийн сахилга батыг чанд сахиж, төсвийн хяналтыг сайжруулна.

2.1.3. Төсвийн ил тод байдлыг хангуулж, “Шилэн данс”-ыг 100 хувь хөтлүүлж хэвшүүлнэ.

2.1.4. Төсөл, тендер, сангуудаас олгох зээлийн шалгаруулалтыг ард иргэд, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын хяналтан доор олон нийтэд ил тод, нээлттэй явуулж, хяналтыг чангатгана.

2.1.5. Өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулна.

##### **2.2. Дэд бүтэц, бүтээн байгуулалт**

2.2.1. Сумын төвийн 11 км засмал замын их засварыг хийж гүйцэтгэнэ./улсын төсөв/

2.2.2. Энхтал багийн Бүрэнтолгой хэсгийн 7 км замыг төв замтай холбосон засмал зам барина. /улсын төсөв/

2.2.3. Эрчим хүч, дулааны бие даасан, тархмал эх үүсвэр байгуулах

хувийн хэвшлийн үүсгэл, санаачилгыг дэмжинэ.

2.2.4. Тариалангийн талбай хоорондох замыг засварлан сайжруулна.

2.2.5. 82 айлын шугамын ажлыг үргэлжлүүлнэ.

2.2.6. Дэлгэр хорооллын замыг сайжруулж стандартад нийцсэн шатыг шинээр барина.

2.2.7. Баян Өлзийт баг болон Энхтал багийн Бүрэнтолгой, 96-р зөрлөгийн хорооллуудыг бүрэн гэрэлтүүлэгтэй болгож камержуулна.

2.2.8. Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хот байгуулалтын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна.

2.2.9. Энхтал багийн байрыг өргөтгөнө.

2.2.10. “Сумандаа сайхан амьдарая” төслийн хэрэгжүүлж залуу төрийн албан хаагчид болон залуу гэр бүлийг орон сууцжуулах ажлын хүрээнд “Залуус хороолол”-г төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран шийдвэрлэнэ.

## Гурав. Байгаль орчин, ногоон хөгжил

Хүрээлэн буй орчинд ээлтэй ногоон хөгжлийг бүхий л талаар дэмжинэ.

### 3.1. Байгаль хамгаалал, ногоон байгууламжийн чиглэлээр

3.1.1. Байгалийн үзэсгэлэнт газрыг орон нутгийн тусгай хамгаалалтанд авч “Эко ногоон төгөл” бий болгож аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

3.1.2. Байгальд ээлтэй тогтвортой үйлдвэрлэл, ухаалаг хэрэглээг хэвшүүлж ногоон хөгжлийн үзэл санааг дэлгэрүүлнэ.

3.1.3. Хог хаягдлыг цогц менежментийг хэрэгжүүлж иргэн бүрийг хогоо ангилж хаях соёлд суралцахыг уриалж хогийн цэгийг тарималжуулах шинэ техниолги нэвтрүүлнэ.

3.1.4. Шинээр газар эзэмших ашиглах иргэн ААНБ-н гэрээнд мод тарих чиглэлээр нэмэлт заалтыг тусгаж хэрэгжүүлнэ.

3.1.5. Сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлж Баян Өлзийт багийн Шар эсгийтийн гууд 50 га газар, Энхтал багийн Өгөөмөр нуурийн өвөр олгой нуурт 50 газрыг ойжуулжна.

3.1.6. Нийтийн эзэмшлийн гудамж талбайг гэрэлтүүлэг гоёл чимэглэлийг ногоон амьдарлын хэв маягаар тохижуулна.

3.1.7. Сумын иргэдийн амралт, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх “Гэрэлт ногоон гэрэлт толгод”-ыг шинээр байгуулна.



3.1.8. Ногоон хөгжлийн сэргэлтийн хүрээнд дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлнэ.

3.1.9. Иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлж, хүүхэд, залуучуудад багаас нь хүрээлэн буй орчноо хайрлан хамгаалах зөв дадал хэвшил суулгаж, экологийн мэдлэг олгоно.

### **Дөрөв. Ухаалаг засаглал, ухаалаг бүтэц, чадварлаг албан хаагч**

Хүний эрх, эрх чөлөө, хууль эрх зүйг дээдэлж, шинжлэх ухаан, дэвшилтэт технологи, их өгөгдөлд суурилсан “Цахим засаглал”-ыг бүрэн нэвтрүүлж, төрийн үйлчилгээг ил тод, шуурхай хүргэнэ.

#### **4.1. Иргэнд ээлтэй төрийн үйлчилгээ**

4.1.1. Иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний шат дамжлагыг бууруулж цахим төрийн албыг нэвтрүүлж “Орхон цахим засаглал”-ыг төлөвлүүлнэ.

4.1.2. Нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагаас шийдвэр гаргах явцад иргэний нийгмийн оролцоог хангах үүднээс бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлнэ.

#### **4.2. Ухаалаг төрийн үйлчилгээ**

4.2.1. Төрийн албан хаагчдын мэдээлэл технологийн мэдлэгийг тасралтгүй дээшлүүлнэ.

4.2.2. Иргэд төрийн байгууллагын албан тушаалтнуудтай цахим хэлбэрээр харилцах соёлыг хэвшүүлнэ.

#### **4.3. Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба**

4.3.1. Иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг, ил тод, үр нөлөөтэй, ухаалаг төрийн албыг төлөвшүүлнэ.

4.3.2. Төрийн албан хаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэл, чиг үүргийн онцлогт тохирсон үе шаттай тасралтгүй сурах боломжийг олож сургалтанд хамруулна.


4.3.3. Баян Өлзийт багийн байрны шинэчлэлийг хийнэ.

#### **4.4. Эрх зүй, батлан хамгаалах, гамшгаас хамгаалах бодлого**

4.4.1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулна.

4.4.2. Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.4.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг





хангуулах, нийтийн эрх ашгийг хамгаалах ажлыг нэгдсэн төлөвлөгөөний дагуу зохион байгуулна.

4.4.4. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, авлигатай тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.


4.4.5. Мансууруулах эм, ургамал, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавьж, зохисгүй хэрэглээнээс урьдчилан сэргийлнэ.

4.4.6. Согтууруулах ундааны хэрэглээ, арихидалтын улмаас хүн амын эрүүл мэндэд учирч байгаа хор уршигаас урьдчилан сэргийлэх

4.4.7. Гамшиг ослын үеийн бэлэн байдлыг хангаж, гамшгийн үеийн үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд гүйцэтгэх чадавхийг сайжруулж, гамшгийн эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж хэвшүүлнэ.

4.4.8. Гамшгийн нөхцөлд бүх нийтийн бэлэн байдлын чадавхийг дээшлүүлэх, бие бялдар, сэтгэл зүйн хөгжлийг нь дэмжихэд чиглэсэн “Иргэний боловсрол” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

4.4.9. Эх оронч үзлийг төлөвшүүлж, цэргийн насны иргэдийн цэргийн боловсролыг дээшлүүлнэ.



**Тав. Хөдөө аж ахуй**

**Эрчимжсэн газар тариалан, МАА-г хослуулан хөгжүүлнэ.**

### 5.1. Газар тариалан

5.1.1. ХАА-н парк ашиглалтын төвийг орон нутгийн өмчит үйлдвэрийн газартаа түшиглэн байгуулж шинэ техник тоног төхөөрөмжийг нэвтрүүлнэ.

5.1.2. Ургац хураах шинэ техникийн хангамжийг нэмэгдүүлж хураалтын үеийн ажиллах хүчний дутагдлыг арилгаж механикжуулалтыг хийнэ.

3.1.3. ХАА-н үйлдвэрлэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй мэдлэгт суурилсан тогтвортой хөгжлийн чиг баримжаатай хөгжүүлж дэвшилтэд технологи иновацийг нэвтрүүлэн мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах хамтын ажиллагааг бэхжүүлж, тариамлын нэр төрлийг олшруулах, эрчимжсэн газар тариаланг хөгжүүлнэ.

5.1.4. Хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлж хамгаалагдсан хөрсний тариалалтыг нэмэгдүүлж хүлэмжийн аж ахуйг цогцоор хөгжүүлэхэд бодлогоор дэмжиж хөгжүүлж шинэ ургацын ногооны хангамжийг нэмэгдүүлнэ.

5.1.5. Таримал ургамлын өвчин, хог ургамал, хөнөөлт шавьж, мэрэгчдийн тархалтын эсрэг байгаль экологид ээлтэй ургамал хамгааллын цогц арга хэмжээг мэргэждийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж зохистой дадлыг хэвшүүлнэ.

5.1.6. Тариалангийн талбайд цахилгаан татах ажлыг үргэлжүүлнэ.

5.1.7. Шарын голын усалтын ситемийн ашиглалтыг сайжруулж орон нутгийн өмчид авах, засварлах ажлыг төсөл хөтөлбөрийн хүрээнд шийдвэрлэнэ.

5.1.8. Цас борооны усыг хуримтлуулан тариалангийн усалгаанд ашиглах зоилгоор хиймэл нуур хөв цөөрмийг байгуулан тариалангийн талбайн нөөц усан цонг байгуулах төслийг улсын төсөв болон ОУБ-ын төсөл хөтөлбөрийн хүрээнд шийдвэрлэнэ.

5.1.9. Хүнсний ногооны үнийг тогтворжуулах зорилгоор механикжсан зоорийг ОУБ-ын төсөл хөтөлбөр болон “Шинэ хөдөө” төслийн хүрээнд шийдвэрлэн зоорийн хангамжийг нэмэгдүүлнэ.

## 5.2. Мал аж ахуй

5.2.1. Газар тариалантай зөв хосолсон эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийн оновчтой хэлбэр, малын төрөл, тоо хэмжээний зохистой бүтэц бүхий эрчимжсэн МАА эрхлэхэд төрийн зүгээс бодлогоор дэмжиж загвар аж ахуйг байгуулна.

5.2.2. Шинэ хөдөө төслийн хүрээнд эрчимсэн МАА эрхлэх чиглэлээр гойд ашиг шимт мал өсгөн үржүүлэхэд төсөл хөтөлбөрт хамруулж малчдыг туршлага судлах сургалтанд хамруулж, “Шинэ хоршоо” төслийг хэрэгжүүлнэ.

5.2.3. Тариалангийн талбайн эргэлтийг нэмэгдүүлж, тэжээлийн ургамал тариалах малчдад тэжээлийн ургамал тариалах газрыг төрийн зүгээс бодлогоор дэмжиж олгох ажлыг зохион байгуулж, тариалалтын зөвөлгөөг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж малчдыг сургалтад хамруулна.

## 5.3. Туслах аж ахуй

5.3.1. Зөгийн аж ахуйг цогц байдлаар үйлдвэрлэлийн хэмжээнд хөгжүүлж зөгийн бал савлах цехийн байгуулж орон нутгийн онцлогт тохируулан тохижуулж, орон нутгийн “Брэнд” бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.

5.3.2. Гахай, тахиаг, шувууг хөгжүүлэхэд төрийн зүгээс дэмжиж үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

## Зургаа. Үйлдвэрлэл, үйлчилгээ

### 6.1. Хүнсний ногооны боловсруулалт ба түгээлтийн үйлчилгээ

6.1.1. Хүнсний ногооны дахин боловсруулах жижиг дунд үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлээр ОУБ-ын төсөл хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ.

6.1.2. Суманд хүнсний ногооны бөөний борлуултын цэгийг байгуулна.

6.1.3. Хүнсний ногоо борлуулах “Орхон-ногоо” захыг Улаанбаатар хотод байгуулж байнгын ажиллагаатай болгох

6.1.4. Орхон хаалганы дэргэдэх үйлчилгээ эрхлэгчдийг төрийн зүгээс бодлогоор дэмжиж дэд бүтцийг шийдвэрлэнэ.

6.1.5. Хүнсний ногоо хадгалах зоорийг нэмэгдүүлнэ.

**6.2. жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх**

6.2.1. Зөгийн бүтээгдэхүүн савлах цехийн ашиглалтыг сайжруулж тогтмолжуулах, “Орхон Брэнд” бүтээгдэхүүн бий болгоно.

6.2.2. Сүү хөргөөх цэгийг байгуулна.

6.2.3. Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхийг төрийн зүгээс бодлогоор дэмжинэ.

